34	Цахилгааны байгууламжийн угсралтын үед дараа зохих хамгаалалт хийгээгүйгээс хүн тогонд цохиулжболзошгүй	- Цахилгааны байгууламж, тоног төхөөрөмжийн хаалгыг цоож, түгжээтэй байлгах аюулгүй ажиллагааны зааваргүйгээр ашиглалтад оруулахыг хориглоно; - Цахилгааны дэд станц, цахилгаан хуваарилах байгууламж ба цахилгааны кабель шугамын угсралтын талбарт орохыг хязгаарласан, анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах; - Цахилгааны байгууламж, тоног төхөөрөмж нь аюулгүй ажиллагааны нөхцөлийг хангахаар бүрэн бүтэн байх ёстой.	- Цахилгааны байгууламж, тоног төхөөрөмжийн хаалгыг цоож, түгжээтэй байлгаж, камераар хянадаг. - “Сейфти Грийн Зон” ХХК нь цахилгааны ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа боловсруулж өгч, баталгаажуулсан.	Барилгын ажлын төсөвт багтсан	
35	Цахилгаан хангамжийн төвшугамд түр салгалт хийх үед ойр орчмын айл өрх, албан	- Цахилгааны байгууламжуудын холболт, угсралтын үед цахилгаан хангамжийн шугамд түр салгалт тохиолдол бүрд тухайн хэсгийн хорооны захиргаа, айл өрх албан байгууллагуудад 3 өдрийн өмнө урьдчилан мэдэгдэх арга хэмжээг авна;	- Цахилгааны байгууламжуудын холболт, угсралтын үед цахилгаан хангамжийн шугамд түр салгалт хийхийн өмнө айлуудад мэдэгдэж нийт 5 айлын тогийг тасалж, урьдчилсан мэдэгдэж арга хэмжээ авч ажилласан.	Барилгын ажлын төсөвт багтсан	

2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН: “ДАМБАДАРЖАА ДУЛААНЫ СТАНЦ БАРИХ” ТӨСӨЛ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөсөн ажил	2024 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, сая.төг
	байгууллагын хэвийн үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй	- Цахилгаан хангамжийн шугамд түр салгалт цагийг ажлын бус өдрүүдэд, оргил ачааллын цагаас зөрүүлэн хийхээр төлөвлөх.			
Нийт					4,200.0
9. Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ					
36	Гүйцэтгэгчийн БОМТ боловсруулах, хэрэгжүүлэх	- Барилгын ажлын гэрээт гүйцэтгэгч нь БОАЖЯ-аар батлагдсан энэхүү БОМТ дээр үндэслэн Г-БОМТ-г боловсруулж ТУН-д хянуулж батлуулна.	- Бид БОАЖЯ-аар батлагдсан БОМТ дээр үндэслэн Г-БОМТ-г боловсруулж ТУН-д хянуулсан.	Барилгын ажлын төсөвт багтсан	
37	БОМТ-г хэрэгжүүлэх бүтэц зохион байгуулалт, боловсон хүчинтэй байх	- Барилгын ажлын гэрээт гүйцэтгэгч байгууллага нь талбайн байгаль орчны ажилтантай байх ба уг ажилтаннь Г-БОМТ-г боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, барилгын ажлын талбарт өдөр тутмын БО-ны хяналт тавих зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.	- Байгаль орчны үнэлгээ, судалгааны “Баялаг Баян Ундарга” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж тухайн жилийн БОМТ-г боловсруулсан. Мөн БОМТ-г хэрэгжүүлэх, тайлагнах, барилгын ажлын талбарт өдөр тутмын БО-ны хяналт тавих зэрэг чиг үүргийг хэрэгжүүлсэн.	Барилгын ажлын төсөвт багтсан	
38	Байгаль орчныг хамгаалах чиглэлээр инженер, барилгын ажилчдыг чадавхжуулах	- Бүх барилгын ажилчдыг хамруулсан БО-ны сургалт зохион байгуулж, БО-ны чиглэлийн хууль, журмын шаардлага, стандарт, БОМТ-д тусгагдсан бууруулах арга хэмжээг тайлбарлан таниулна.	- Бүх барилгын ажилчдыг хамруулсан ХАБЭА болон БО-ны чиглэлээр сургалт зохион байгуулж, БО-ны чиглэлийн хууль, журмын шаардлага, стандарт, БОМТ-д тусгагдсан бууруулах арга хэмжээг тайлбарлан таниулна.	Энэхүү төлөвлөгөөний 8-р хэсэгт заагдсан сургалтын төсвийн хүрээнд	
39	Аюулгүйн бүс	- Станцын аюулгүй бүсийг холбогдох хууль журмын дагуу тогтоон гаргаж өгөх	- Баталгаажсан зураг төслийн дагуу дагаж мөрдөж байна.	Станцын зураг төсөл боловсруулах зардал ба барилгын ажлын зардалд багтсан.	
Нийт				-	

2.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлтийн дэлгэрэнгүй

Чингэлтэй дүүргийн 19-р хорооны Засаг даргатай хог хаягдлын үйлчилгээний хураамжийг хураан төвлөрүүлэх гэрээ байгуулж энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлүүлж байна (Хавсралт-1).

2024 оны 09 сарын 12-ны өдрөөс 10 сарын 13-ны өдрүүдэд барилгын газар шорооны хийгдэж нийт 1249 удаа рейс хийж 19840 м³ шороо гарсан. Дээрх шороог станцын хашааны тэгшилгээнд ашиглаж, үлдсэн шороог нийгмийн хариуцлагын хүрээнд нүүлгэн шилжүүлэлт хийгдэж буй хорооны айл өрхүүдийн хашаанд буулгаж, тэгшилгээд хэрэглэсэн. Станцын хашаанд 6500 м³ шороог овоолж нөхөн сэргээлтэд ашиглахаар төлөвлөж байна.

- Мөн хаягдал шороон материалын хэмжээ, овоолго, ачиж зайлуулсан тоо хэмжээний бүртгэлийг өдөр тутам хөтөлж, 7 хоног бүр ТУН-д тайлагнаж байсан. Тайланг дараах байдлаар явуулсан (Хавсралт-2).
Төслийн талбай нь Сэлбийн гүүрнээс баруун зүгт 318 метрийн зайд байрлана. 2024 оны 08 сарын 14-ны өдрийн А/64 дугаартай Туул голын сав газрын захиргааны даргын тушаалаар “China second metallurgy group” ХХК-д Ус шавхан зайлуулах зөвшөөрөл олгосон. Дээрх тушаалын хүрээнд Сэлбэ гол руу ус шавхан зайлуулж байсан (Хавсралт-3).
- 2024 оны 07 сарын 17-ны өдөр №ХУЗ-24/0717-01 дугаартай Хөрсний ус шавхан зайлуулах ажил гүйцэтгэх гэрээг “Канда” ХХК-тай байгуулж, гэрээний дагуу хөрсний усыг зайлуулсан. Холбогдох аргачлалыг бидэнд англи хэл дээр үйлдэж өгсөн (Хавсралт 4-5).
- Барилгын ажил 2024 оны 09 сард эхэлсэн. Одоогоор төслийн талбайд нийт 15 хүн ажиллаж байна. Ахуйн шингэн хог хаягдлыг 10 тн, 15 тн-ны багтаамжтай 2 ширхэг зориулалтын саванд цуглуулж байна.
- Боловсон ариун цэврийн байгууламж байгуулсан. Өдөр бүр үйлчлэгч ариун цэврийн байгууламжийг ариутгаж, угааж цэвэрлэдэг.

Зураг 7. Ариун цэврийн байгууламжийн гадна харагдах фото зураг



Зураг 8. Ариун цэврийн байгууламжийн дотор талын фото зураг



- Зүсэх, гагнах ажлууд хийгдэх талбайг тохижуулан, тэмдэглэгээ байршуулсан.

Зураг 9. Зүсэх, гагнах талбайг тохижуулсан фото зураг



- 2024 оны 07 сарын 17-ны өдрийн 9941606 дугаартай хамтран ажиллах гэрээг ХАБЭА чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Сейфти Грийн Зон” ХХК-тай байгуулсан байна. ХАБЭА инженер ажиллаж өдөр бүр ажилчдад зааварчилгаа өгч ажиллаж байсан (Хавсралт-6).
- Барилгын ажлын талбайд “Сейфти Грийн Зон” ХХК-ийн ХАБЭА инженер ажиллаж өдөр бүр ажилчдад зааварчилгаа өгч, ажилчдад нэгдсэн байдлаар сургалт орсон.

Зураг 10. Сейфти Грийн Зон” ХХК-ийн ХАБЭА инженер нийт ажилчдад сургалт орж буй фото зураг №1



Зураг 11. Сейфти Грийн Зон” ХХК-ийн ХАБЭА инженер нийт ажилчдад сургалт орж буй фото зураг №2



- Хөдөлмөр Нийгмийн, Хамгааллын сайдын 2023 оны 12 сарын 06-ны өдрийн А/173 тоот тушаалаар батлагдсан хөтөлбөрийн дагуу “Амжилтын боломж гарц” НҮТББ-ын дэргэдэх “Амжилт гарц” мэргэжлийн сургалтын төвд “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн” нийт ажилтны 12 цагийн сургалтад хамрагдаж №22072609С тоот зөвшөөрлийн дагуу Сертификат авсан байна (Хавсралт-7).
- Цахилгааны байгууламж, тоног төхөөрөмжийн хаалгыг цоож, түгжээтэй байлгаж, камераар хянадаг.

Зураг 12. Цахилгааны байгууламж, тоног төхөөрөмжийн хаалгыг цоож, түгжээтэй байлгаж, камераар хянадаг.



- “Сейфти Грийн Зон” ХХК нь цахилгааны ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны заварчилгаа боловсруулж өгч, баталгаажуулсан (Хавсралт-8).



НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Барилгын ажил 2024 оны 09 сард эхэлж газар шорооны ажил болон барилын суурийн цутгалтын бэлтгэл ажлууд хийгдэж байна. Бид MNS 5916:2008 “Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт” стандартыг баримтлан шимт хөрсийг хуулж, шимт хөрсний овоолго үүсгэсэн. 2024 онд төслийн талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийгдэхгүй.

Хүснэгт 1. ДАНР гэрээний дугаартай Дулааны станц барих талбайн техникийн нөхөн сэргээлтийн зардлын тооцоо

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Нийт ажлын хэмжээ, м ³	Нийт ажлын зардал, төгрөг	Нийт зардлын дүн, төгрөг
Техникийн нөхөн сэргээлт					
1	Шимт хөрс хамгаалах арга хэмжээ	М ³	1154.4	500	577,200
Нийт дүн					577,200

ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн барилгын ажлаас үүсэх тоосжилт, дуу чимээ, машин техникийн хөдөлгөөн зэрэг нь станцын хойд талд байрлах Дамбадаржаа хийдээс 800 метрийн зайтай тул нөлөөлөлд өртөхгүй. Төслийн хүрээнд нийгмийн барилга байгууламж баригдах талбай, тэдгээрийн ойр орчимд түүх, соёлын өв, дурсгалт газрууд байхгүй болох нь төсөл хэрэгжих талбайд хийгдсэн суурь судалгааны явцад тогтоогдсон.

Хүснэгт 2. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөсөн ажил	2024 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
	1	2	3
1	Өмнө нь судалж тогтоож чадаагүй археологийн болон түүх соёлын үлдэц, үнэт зүйлс барилгын ажлын үед өртөж болзошгүй	Газар дээр ил гараагүй байсан археологийн буюу палеонтологийн зүйлс санамсаргүй байдлаарилэрсэн тохиолдолд тухайн цэг дээрх барилгын ажлыг түр зогсоож, дүүрэг хорооны захиргаа болон уг асуудлыг хариуцсан байгууллагад нэн даруй мэдэгдэж холбогдох арга хэмжээ авах.	Энэхүү төсөлд түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө боловсруулан ажиллах шаардлага байхгүй болно.
Нийт дүн			

ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний осол эрсдэлийн менежментийн хүрээнд төлөвлөсөн ажил	2024 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
1	2	3	4	5	
1. БАЙГАЛИЙН АЮУЛ, ГАМШИГТ НӨХЦӨЛ БАЙДАЛ					
1	Үерийн эрсдэл	<ul style="list-style-type: none"> - Барилгын түр кэмп, хөрсний овоолгыг үерт өртөхөөргүй газарт сонгож байршуулах; - Шугам хоолой тавих шуудуу ухах газар шорооны ажлыг хур борооны улирлаас урьтаж хийж дуусгах; - Гамшгаас хамгаалах Онцгой байдлын төлөвлөгөө боловсруулж холбогдох байгууллагаар батлуулж, хэрэгжүүлэх. 	<ul style="list-style-type: none"> - Барилгын ажил 2024 оны 09 сард эхэлж газар шорооны ажил болон барилын суурийн цугалтын бэлтгэл ажлууд хийгдэж байна. Барилгын кемпийн барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулсан, хөрсний овоолгыг үер усанд өртөхөөргүй газар байршуулсан. - 2024 онд шугам хоолойны ажил хийгдээгүй. - Иймд бид 2025 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг бүхэлд нь тусгаж хэрэгжүүлж ажиллах болно. 	Үйл ажиллагааны зардал багтсан	
2	Газар хөдлөлтийн аюул, эрсдэл	<ul style="list-style-type: none"> - Онцгой байдлын үед гамшгаас хамгаалах арга хэмжээ авах талаарх сургалтад барилгын ажилчид, инженерүүдийг хамруулах. 		-	-
3		<ul style="list-style-type: none"> - Газар хөдлөлтийн үед цугларах цэг тогтоож, самбар байршуулах. 		-	-
4		<ul style="list-style-type: none"> - Нийгмийн барилга байгууламж барих газрын хөрсний шинж байдлын судалгааг иж бүрнээр хийж газар хөдлөлтийн бичил мужлалын нарийвчилсан зурагт тусгах - Барилга, байгууламжийн үндсэн бүтээгдэхүүний чанар, материалын орц, бүтээцэд хяналт тавих, чичирхийлэлд тэсвэрлэх чадварыг шалгах; - Барилга, байгууламжуудыг паспортжуулах, ашиглалтын чанар байдалд үнэлгээ өгөх. 		Барилгын зураг төсөл боловсруулах зардал багтсан	
5	Гал түймрийн аюул эрсдэл	<ul style="list-style-type: none"> - Ажилчдын түр кемпэд галын пункт байгуулж гал унтраах багаж төхөөрөмжөөр хангах; - Барилгын ажилчдад тогтмол зааварчилгаа өгч ажиллах; - Галын болзошгүй аюул, ослын үед авах арга хэмжээний бэлтгэл, зохион байгуулалтын ажлыг “Галын аюулгүй байдлын тухай хууль”-ийн шаардлагад нийцүүлж хийх; 		-	-

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний осол эрсдэлийн менежментийн хүрээнд төлөвлөсөн ажил	2024 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
		<ul style="list-style-type: none"> - Гал гарсан тохиолдолд газар авхуулахгүй унтраах анхан шатны арга хэмжээ авах, Онцгой байдлын албанд цаг алдалгүй мэдээлэх; - Гал түймрийн аюултай тоног төхөөрөмжийг тавигдаж буй шаардлагын түвшинд стандартын дагуу тусгаарласан өрөө, ил талбайд байрлуулах; - Цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалтын дүрэм, стандартын шаардлага хангасан эсэхэд хяналт тавих; - Цахилгааны байгууламж, тоног төхөөрөмжөө аянга цахилгаанаас хамгаалж буй байдалд хяналт тавих; - Шинээр баригдах нийгмийн барилга байгууламжуудад гал түймрээс хамгаалах систем төлөвлөж өгөх. 			
2. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ШАЛТГААЛАХ ОСОЛ, ЭРСДЭЛ					
2.1. Газар шорооны ажил					
6	Шугам хоолой тавих шуудуунд хүн унах	- Газар шорооны ажил идэвхтэй явагдаж буй цэгийг тойруулан хамгаалалтын хашлага татаж анхааруулах тэмдэг байрлуулах.	- Газар шорооны ажил идэвхтэй явагдаж буй цэгийг тойруулан хамгаалалтын хашлага татаж анхааруулах тэмдэг байрлуулж ажилласан.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд заасны дагуу	
7	Газар ухах ажлын үед хөрсөнд нуралт үүсэж осол гарах	- Ажил эхлэхийн өмнө, ажлын явцад хэвгий хэсэг, хөрсний бүтцийг шалгах, ачааны машины даацыг тохируулах, нурах эрсдэлтэй газарт ажилчид нэвтрэхийг хориглох, хөрсийг тохирсон хэмжээнд ухах.	- Хөдөлмөр хамгааллын аюулгүй байдлыг хангаж хөрсийг тохирсон хэмжээнд ухаж ажиллаж, талбайн инженер шаардлага тавьж ажилласан.		
8	Гинжит экскаватор газар ухах явцад осол гаргах	- Машин механизмын бүрэн бүтэн байдлыг шалгах, машин механизмын ард улаан гэрэл, самбар тавих, машин механизмыг ашиглах явцад дохиочныг талбайд ажиллуулан бусад ажилчин орохыг хориглох.	- Машин механизмын бүрэн бүтэн байдлыг шалгаж, машин механизмын ард улаан гэрэл, самбар тавьж, машин механизмыг ашиглах явцад дохиочныг талбайд ажиллуулан бусад ажилчин орохыг хориглож ажиллаж байсан.	Үйл ажиллагааны зардалд багтсан	
9	Кабель, холбооны утас шугамыг хөндөж гэмтээх	- Газар шорооны ажил явагдах орчинд буй шугам сүлжээний схем, зургийг сайтар судалж ажлаа төлөвлөх, инженерийн хяналт тавих.	- Газар шорооны ажил явагдах орчинд буй шугам сүлжээний схем, зургийг сайтар судалж ажлаа төлөвлөн, инженерийн хяналт тавьж ажилласан.		
2.2. Шугам хоолойн угсралт, суурилуулалтын ажлууд					

2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН: “ДАМБАДАРЖАА ДУЛААНЫ СТАНЦ БАРИХ” ТӨСӨЛ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний осол эрсдэлийн менежментийн хүрээнд төлөвлөсөн ажил	2024 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
10	Гагнуурын оч үсэрч хүн гэмтэх	- Зориулалтын хөдөлмөр хамгааллын хэрэгсэл өмсөх, гагнуур хийгдэж буй цэгийг хашиж хамгаалах.	- Нийт ажилчдад хөдөлмөр хамгааллын хувцсаар хангаж ажилласан.	Үйл ажиллагааны зардалд багтсан	
11	Зүсэх, бутлах ажлын үед осол гарах	- ХААБ-ын стандарт журмыг мөрдөх, хамгаалах хэрэгсэл өмсөх.	- “Сейфти Грийн Зон” ХХК-ийн ХАБЭА инженерт тогтмол хяналт тавьж, хамгаалах хэрэгсэл өмсгөж, стандарт журмыг мөрдүүлж ажиллуулж байсан.		
12	Тогонд цохиулах	- ХААБ-ын стандарт журмыг мөрдөх, хамгаалах хэрэгсэл өмсөх.			
2.3. Барилга угсралтын ажил					
13	Өндрөөс юм унаж хүн гэмтээх	- ХААБ-ын стандарт журмыг мөрдөх, хамгаалах хэрэгсэл өмсөх, барилга баригдаж буй талбайг тойруулан хамгаалалтын хашлага татаж, анхааруулах тэмдэглэгээ байршуулах, шаардлагатай тохиолдолд хамгаалалтын саравч бүхий зам төлөвлөж өгөх.	- Явган зорчигчийг гэмтээх болон бусад машин тэрэгтэй мөргөлдөх эрсдэл гараагүй. Нийт ажилчид ХАБЭА нь хувцас хэрэгсэл ээ тогтмол өмсөж, өдөр бүр зааварчилгаа авч ажилласан.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд заасны дагуу	
14	Ачаа өргөх үед тросс тасрах	- Ачаа өргөх троссын бүрэн бүтэн байдлыг шалгах, ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, тросс өргөх чиглэлд хүн явуулахгүй байх.	- Ажилчдад ажлын талбайд гарахаас өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгааг ХАБЭА инженер тогтмол өгч байсан.	Үйл ажиллагааны зардалд багтсан	
15	Зүсэх, бутлах ажлын үед осол гарах	- ХААБ-ын стандарт журмыг мөрдөх, хамгаалах хэрэгсэл өмсөх.	- ХААБ-ын стандартыг тогтмол хангаж ажиллаж байсан.	Үйл ажиллагааны зардалд багтсан	
16	Химийн хорт ба аюултай бодис агуулаагүй барилгын материал сонгож ашиглах	- Төслийн барилгын ажилд VOC зэрэг химийн нэгдлүүд, хорт ба аюултай бодис агуулсан материал хэрэглэхээс татгалзах, зайлшгүй хэрэглэх болсон тохиолдолд мэргэжлийн байгууллагаар химийн бодисын эрсдэлийн үнэлгээг хийлгэх шаардлагатай.	- Төслийн барилгын ажилд VOC зэрэг химийн нэгдлүүд, хорт ба аюултай бодис агуулсан материал хэрэглээгүй.	Үйл ажиллагааны зардалд багтсан	
2.4. Зам барилгын ажил					
17	Бетон насосын машин суурилуулахад осол гарах	- Бетон зуурмагийн машин ухрах, хөдлөх үед дохиочин ажиллуулах, хамгаалалтын хувцас хэрэглэл өмсөх, ажлын хувцас өмсөөгүй хүнийг талбай руу ойртуулахгүй байх.	- Барилгын ажил 2024 оны 09 сард эхэлж газар шорооны ажил болон барилын суурийн цутгалтын бэлтгэл ажлууд хийгдэж байна.	Үйл ажиллагааны зардалд багтсан	
18	Зам индүүдэгч, зуурмаг шахагч	- Ухрах, эргэх маневрыг зөвхөн дохиочны заавраар хийх.			

2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН: “ДАМБАДАРЖАА ДУЛААНЫ СТАНЦ БАРИХ” ТӨСӨЛ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний осол эрсдэлийн менежментийн хүрээнд төлөвлөсөн ажил	2024 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
	машин механизмууд осол гарах				
19	Өндөр температуртай асфальт алдагдах, түүнд түлэгдэх	- Ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа ажил эхлэхээс өмнө өгөх, хувийн хамгаалалтын хувцас хэрэглэл өгч хэрэглүүлэх.			
20	Хучилт хийх тоног төхөөрөмж эвдрэх	- Урьдчилсан төлөвлөгөө гаргах, машин механизмын бүрэн бүтэн байдлыг тогтмол хянах, шаардлагатай засвар үйлчилгээг цаг тухайд нь хийх.			
21	Зам доогуур тавьсан ус нэвтрүүлэх хоолой бөглөрөх	- Ус нэвтрүүлэх хоолойнуудыг жил бүр цэвэрлэж хуримтлагдсан хог хаягдал, хагшаасыг зайлуулж байх.		Нийслэл хотын зам засвар, арчилгааны төсвөөс санхүүжнэ.	
2.5. Барилгын материал тээвэрлэх, ачих буулгах үйл ажиллагаа					
22	Барилгын ажилд ашиглагдаж буй машин явган зорчигчийг мөргөж гэмтээх буюу бусад машин тэрэгтэй мөргөлдөх	- Жолооч нарыг замын хөдөлгөөний аюулгүй ажиллагааны сургалтад давтан хамруулах, аюулгүй ажиллагааны журмыг чанд мөрдүүлэх, техникийн бүрэн байдлыг тогтмол шалгах, гэр хороолол доторх замд хурдны хязгаар тогтоох.	- Барилгын ажлын талбайд “Сейфти Грийн Зон” ХХК-ийн ХАБЭА инженер ажиллаж тээврийн хэрэгслийн жолооч, оператор, ажилчдыг ажлын талбайд гарахаас өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгааг танилцуулж ажиллаж байсан.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд заасны дагуу	
23	Барилгын материал ачижбуулгах явцад осол гарах	- Ачаа өргөх троссын бүрэн бүтэн байдлыг шалгах, ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, тросс өргөх чиглэлд хүн явуулахгүй байх.	- Барилгын ажил 2024 оны 09 сард эхэлж газар шорооны ажил болон барилын суурийн цутгалтын бэлтгэл ажлууд хийгдэж байна.	Үйл ажиллагааны зардалд багтсан	
Нийт дүн				-	

Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

- Газар шорооны ажил идэвхтэй явагдаж буй цэгийг тойруулан хамгаалалтын хашлага татаж анхааруулах тэмдэг байрлуулж ажилласан.

Зураг 13. Газар шорооны ажил явагдаж байгаа талбайг тойруулан тэмдэглэгээ байршуулсан болон Ажилчдын ХАБЭА хувцаар хангаж ажиллаж буй фото зураг



ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Хог хаягдлын ангилал	2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд төлөвлөсөн ажил	2024 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	Нэгжийн өртөг, ₮	Нийт зардал, ₮
1	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	<ul style="list-style-type: none"> - Барилгын ажлын гэрээт гүйцэтгэгч байгууллага нь Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулж ТУН-ээр хянуулж, хэрэгжүүлж ажиллана. - Сүхбаатар дүүргийн тохижилт үйлчилгээний газартай хог хаягдлын гэрээ байгуулж ажиллах 	<ul style="list-style-type: none"> - 2024 оны 09 сарын 12-ны өдрөөс 10 сарын 13-ны өдрүүдэд барилгын газар шорооны хийгдэж, одоо барилгын суурийн цуггалтын бэлтгэл ажлууд хийгдэж байна. - Чингэлтэй дүүргийн 19-р хорооны Засаг даргатай хог хаягдлын үйлчилгээний хураамжийг хураан төвлөрүүлэх гэрээ байгуулж энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлүүлж байна. - Барилгын ажил 2024 оны 09 сард эхэлсэн. Одоогоор төслийн талбайд нийт 15 хүн ажиллаж байна. Ахуйн шингэн хог хаягдлыг 10 тн, 15 тн-ны багтаамжтай 2 ширхэг зориулалтын саванд цуглуулж байна. - Боловсон ариун цэврийн байгууламж байгуулсан. Өдөр бүр үйлчлэгч ариун цэврийн байгууламжийг ариутгаж, угааж цэвэрлэдэг. - Барилгын ажил оройтож эхэлсэнтэй холбогдуулан бүтээн байгуулалтын ажлыг бид шат дараалалтай хийж байна. Иймд 2025 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг бүрэн хийж гүйцэтгэх болно. - 2024 оны 09 сарын 12-ны өдрөөс 10 сарын 13-ны өдрүүдэд барилгын газар шорооны хийгдэж нийт 1249 удаа рейс хийж 19840 м³ шороо гарсан. Дээрх шороог станцын хашааны тэгшилгээнд ашиглаж, үлдсэн шороог нийгмийн хариуцлагын хүрээнд нүүлгэн шилжүүлэлт хийгдэж буй хорооны 	Үйл ажиллагааны зардалд багтсан	
2	Ахуйн хог хаягдлын менежмент	- Барилгын түр кемпэд ахуйн хатуу хог хаягдлыг түр цуглуулах цэгтогтоож, хашлага хамгаалалт хийж тэмдэгжүүлэх			
		- ЧД-ийн ТҮК-тэй хог хаягдлыг тээвэрлэх гэрээ байгуулж цугларсан хог хаягдлыг хог хаягдлын нэгдсэн цэгт тээвэрлэн хүргэх ажлыг гүйцэтгүүлэх			
		- Хог хаягдлыг замбараагүй хаях, зөвшөөрөлгүй газарт хураах, цуглуулахыг хатуу хориглох			
		- Барилгын ажил явагдаж буй газруудад зориулалтын хогийн сав байрлуулах			
		- Барилгын түр кемпээс үүсэх шингэн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулж байх			
		- Барилгын түр кемпийн 00-н нүхэнд бактерийн бохирдлоос сэргийлэх био-бэлдмэл хэрэглэж, ойр орчмыг хлораминт цацлагаар тогтмол ариутгаж цэвэрлэж байх			
		- Хог хаягдлын менежмент, талбайн үзлэгийг өдөр тутамд зохион байгуулж хяналт тавих			
3	Барилгын хог хаягдлын менежмент	- Барилгын хог хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулах хэрэгцээ, төрлөөр нь ангилан ялгана.			
4		- Барилга, байгууламж, явган хүний зам талбай, ногоон байгууламж барих, шинэчлэх, өргөтгөх, засварлах, тоноглох, буулгахад үүсэх хог хаягдлыг бүрэн цэвэрлэж, талбайг чөлөөлнө.			
5		- Барилгаас үүссэн дахин боловсруулах боломжгүй хог хаягдлыг зайлуулах зөвшөөрлийг СБД ба ЧД-ийн Засаг даргаас авч, хог хаягдлын төвлөрсөн цэгт тээвэрлэн зайлуулна.			

2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН: “ДАМБАДАРЖАА ДУЛААНЫ СТАНЦ БАРИХ” ТӨСӨЛ

№	Хог хаягдлын ангилал	2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд төлөвлөсөн ажил	2024 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	Нэгжийн өртөг, ₮	Нийт зардал, ₮
6		- Барилгын хог хаягдал тээвэрлэх ажлыг тусгай зөвшөөрөл бүхий байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр хийж гүйцэтгүүлнэ.	айл өрхүүдийн хашаанд буулгаж, тэгшилгээд хэрэглэсэн. Станцын хашаанд 6500 м ³ шороог овоолж нөхөн сэргээлтэд ашиглахаар төлөвлөж байна. - Мөн хаягдал шороон материалын хэмжээ, овоолго, ачиж зайлуулсан тоо хэмжээний бүртгэлийг өдөр тутам хөтөлж, 7 хоног бүр ТУН-д тайлагнаж байсан.		
7		- Барилгын хог хаягдал тээвэрлэх машиныг Аймаг, нийслэлийн нэгдсэн GPS-ийн хяналтын системд бүртгүүлсэн байх хог хаягдлыг зориулалтын цэгээс бусад газар хаяхгүй байх			
8		- Барилгын хог хаягдал тээвэрлэх тэвштэй буюу өөрөө буулгагч тээврийн хэрэгсэл нь хог хаягдлыг гээгдэхээс хамгаалах зориулалтыг хэрэгсэлтэй, өндөрлөгөө, хашлага, бүтээлэгтэй байх			
9	Хаягдал шороон материалын менежмент	- Барилгын суурь ухах ажлаас үүсэх 27,034 м ³ хаягдал шороон материалыг Цагаандавааны хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэн зайлуулах зөвшөөрлийг СБД ба ЧД-ийн захиргаанаас авч, хог хаягдлын гэрээнд тусган оруулж өгнө.			
10		- Хаягдал шороон материалыг их хэмжээгээр хуримтлуулалгүйгээр тухай бүрд зайлуулж байх			
11		- Гэрээт гүйцэтгэгч нь хаягдал шороон материалын ялгарал, овоолго, ачиж зайлуулсан тоо хэмжээний бүртгэлийг өдөр тутам хөтөлж, 7 хоног бүр ТУН-д тайлагнана.			
Нийт дүн:					-

ОРЧНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР (ОХШХ)-ИЙН БИЕЛЭЛТ

Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд “Дамбадаржаа дулааны цахилгаан станц”-ын төслийн 2024 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн хөндлөнгийн мониторингийн хээрийн судалгааг бид хоёр удаагийн давтамжтай буюу 2024 оны 06 сарын 25 болон 2024 оны 10 сарын 03-аас 08-ны өдөр Байгаль орчны үнэлгээ, судалгааны “Баялаг Баян Ундарга” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн байна.

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэг байршил	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
	1	2	3	4	5
Хөрсөн бүрхэвч					
1	- Хөрсний агрохимийн үзүүлэлт, хүнд металлын зарим элементүүд (Pb, Zn, Cd, Cr, Ni, Co)-ийг тодорхойлох,	- Төслийн талбайд 2 цэгт	Хөрсний агрохими, хүнд металл, хөрсний эрүүл ахуйн дээжийг 200-300 гр хэмжээтэй авч “Инженер геодези” ХХК-ийн хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн (шинжилгээний үр дүнг хавсралтаар хавсаргав).	-	116,600
Агаарын чанар					
2	Агаарын чанар, физик бохирдлыг тодорхойлох зорилгоор NO ₂ , SO ₂ болон нийт тоос, дуу чимээ зэрэг үзүүлэлтийг тодорхойлох	- Төслийн талбайд 2 цэгт	Агаарын чанарын дээжийг 2 цэг тус бүрээс сорьц авч Цаг уур орчны шинжилгээний газар Байгаль орчин, хэмжилзүйн төв лабораторид шинжлүүлсэн (шинжилгээний үр дүнг хавсралтаар хавсаргав).	-	129,000
Усны чанар					
3	Усны чанарын үндсэн үзүүлэлт	- Унд, ахуйн хэрэглээний уснаас-1 цэг - Хөрсний шүүрлийн уснаас-1 цэг	Унд, ахуйн хэрэглээний уснаас нэг усны сорьц авч “Инженер геодези” ХХК-ийн хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн (шинжилгээний үр дүнг хавсралтаар хавсаргав).	-	108,900
Нийт дүн					354,500.0

Зураг 14. Төслийн талбайд хийгдсэн мониторингийн цэгийн байршлын зураг

Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр, 2 дугаар үе шат



Зураг 15. Орчны хяналт шинжилгээ хийх ажлын явц



Зураг 16. Агаарын сорьц, дуу чимээ хэмжсэн багаж хэрэгсэл



7.1 Агаарын чанарын хяналт-шинжилгээ

7.1.1 Судалгааны зорилго

“Дамбадаржаа дулааны цахилгаан станц”-ын төслийн 2024 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн хөндлөнгийн мониторинг судалгаагаар агаарын чанарын хяналт шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөхийг зорьсон.

7.1.2 Судалгааны байршил, хамрагдсан цэгүүд

Хүснэгт 3. Агаарын чанарын хяналт шинжилгээ хийсэн цэгийн байршил

Агаар		Координат	Цэг сонгосон үндэслэл
1	1-р цэг ЧД, 19-р хороо төслийн талбайн барилга баригдаж байгаа талбай	47°58'38.79"N 106°55'13.50"E	2024 оны БОМТ-нд тусгагдсан хяналт шинжилгээний цэг
2	2-р цэг ЧД, 19-р хороо төслийн талбайн хашааны гадна тал	47°58'36.39"N 106°55'15.59"E	

3.1.3. Судалгааны арга, дээж авалт

Төслийн талбайгаас агаарын хүхэрлэг хий (SO_2), азотын давхар исэл (NO_2), нийт тоос (нийт жинлэгдэгч бодис) болон дуу шуугиан үзүүлэлт тус бүрийг хээрийн судалгаа болон лабораторийн шинжилгээний үр дүнгээр тодорхойлов. Үүнд:

- **Хүхэрлэг хий болон азотын давхар исэл:** Хүхэрлэг хий болон азотын давхар ислийг тодорхойлохдоо химийн шинжилгээний аргачлалаар тодорхойлсон.
 - **Хүхэрлэг хий:** Агаараас тетрахлормеркурат натрийн уусмал /ТХМ/-аар норгосон шингээгч гуурсанд 2 л/мин хурдтайгаар 20 минутын турш агаараас сорьц авч шингээгч гуурсны шилэн бөмбөлгийн давхаргад шингэсэн хүхэрлэг хийг лабораторийн нөхцөлд усан уусмалд шилжүүлж тэр уусмал дээрээ формальдегид, парарозаналины уусмал нэмэхэд үүссэн нэгдлийн өнгөний эрчимжлийг спектрофотометрээр хэмжин хүхэрлэг хийн агууламжийг тодорхойлов;
 - **Азотын давхар исэл:** Агаараас азотын давхар ислийг үл хатах мышьяклаг хүчлийн натрийн давс агуулсан кали иодын уусмалаар норгосон шингээгч гуурсаар 0.25 л/мин-ын хурдтайгаар 20 минутын турш соруулан сорьц авч шингээгч гуурсны шилэн бөмбөлгийн давхаргад шингээж лабораторийн нөхцөлд уусмалд шилжүүлж үүссэн нитрит ион сульфанины хүчилтэй харилцан үйлчилж диазо нэгдлийг үүсгэх бөгөөд тэр нь -нафтиламинтай урвалд орж азобудагч бодисыг уусмалын өнгөний эрчимжлээр азотын давхар ислийн хэмжээг тодорхойлов.
- **Нийт тоос (Нийт жинлэгдэгч бодис):** Төслийн талбай орчмын агаарт агуулагдах нийт тоос (Нийт жинлэгдэгч бодис)-ны агууламжийг DustTrak 8530 зөөврийн багажийн тусламжтай тодорхойлсон;
- **Дуу чимээ:** Шуугианы хэмжилтийг MNS 5003:2000 “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугиан хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага.” стандарт аргачлалын дагуу EXTECH Noise Dosimeter, Datalogger, and Sound Level Meter SL355) загварын зөөврийн багажаар тодорхойлсон.

7.1.3 Судалгаанд ашигласан багаж хэрэгсэл



Зураг 17. DustTrak 8530 загварын зөөврийн багаж



Зураг 18. EXTECH Noise Dosimeter, Datalogger, and Sound Level Meter SL355 загварын зөөврийн багаж


7.1.4 Хяналт шинжилгээний дүн

Агаарын чанарын хяналтын 2 цэгээс авсан нийт тоосны хэмжээг MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандарттай харьцуулахад хүлцэх агууламжаас даваагүй, хэвийн хэмжээнд байна.

Хүснэгт 4. Нийт тоос /Нийт жинлэгдэгч бодис/ хэмжилтийн үр дүн

№	Сорьц авсан цэг	Нийт тоос /Нийт жинлэгдэгч бодис/мкг/м ³
1	1-р цэг ЧД, 19-р хороо төслийн талбайн барилга баригдаж байгаа талбай	0.181
2	2-р цэг ЧД, 19-р хороо төслийн талбайн хашааны гадна тал	0.200
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016		0.500

График 1. Төслийн талбайн 19-р хорооны нутгаас авсан агаарын чанарын нийт тоосонцрын агууламж



3.1.5.1. Агаарын бохирдуулагч бодисын хэмжилт

Агаарын чанарын хяналтын 2 цэгээс авсан хүхэрлэг хий болон азотын давхар ислийн хэмжээг MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандарттай харьцуулахад хүлцэх агууламжаас давсан үзүүлэлт илрээгүй хэвийн хэмжээнд байна.

Хүснэгт 5. Агаарын бохирдуулагч бодисын хэмжилтийн үр дүн

№	Сорьц авсан цэг	NO ₂ (Азотын давхар исэл мг/м ³)	SO ₂ (Хүхэрлэг хий мг/м ³)
1	1-р цэг ЧД, 19-р хороо төслийн талбайн барилга баригдаж байгаа талбай	0.024	0.015
2	2-р цэг ЧД, 19-р хороо төслийн талбайн хашааны гадна тал	0.029	0.012
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016		0.200	0.450




График 2. Төслийн талбайн 19-р хорооны нутгаас авсан агаарын чанарын азотын давхар исэл, хүхэрлэг хийн агууламж

3.1.5.2. Дуу шуугианы хэмжилт

Дуу шуугианы үзүүлэлтийг хяналтын 2 цэгийн ойр орчимд хэмжсэн ба үр дүнг MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандарттай харьцуулахад төслийн талбайн ойролцоо зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан үзүүлэлт байхгүй байна.

Хүснэгт 6. Дуу шуугианы хэмжилтийн үр дүн

№	Сорьц авсан цэг	Дуу чимээ дБ (А)
1	1-р цэг ЧД, 19-р хороо төслийн талбайн барилга баригдаж байгаа талбай	62

№	Сорьц авсан цэг	Дуу чимээ дБ (А)
2	2-р цэг ЧД, 19-р хороо төслийн талбайн хашааны гадна тал	54
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 дБ (А), 16 цагийн дундаж		60

7.1.5 Дүгнэлт, зөвлөмж

Төслийн талбайн 19-р хорооны нутгаас агаарын хүхэрлэг хий (SO_2), азотын давхар исэл (NO_2), нийт тоос (Нийт жинлэгдэгч бодис) болон дуу шуугиан хэмжилт хийж гарсан үр дүн тус бүрийг MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандарттай харьцуулахад зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс даваагүй байна.

7.2 Хөрсний хяналт-шинжилгээ

7.2.1 Судалгааны зорилго

“Дамбадаржаа дулааны цахилгаан станц”-ын төслийн 2024 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн хөндлөнгийн мониторинг судалгаагаар хөрсний доройтол, бохирдол, төрөл зэрэглэлийг тогтоож хяналт шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөхийг зорьсон.

7.2.2 Судалгааны байршил

Хүснэгт 7. Хөрсний хяналт шинжилгээ хийсэн цэгийн байршил

Хөрс	Координат	Цэг сонгосон үндэслэл
1 1-р цэг ЧД, 19-р хороо төслийн талбайн барилга баригдаж байгаа талбай	47°58'38.63"N 106°55'13.49"E	Хөрсний үндсэн хэв шинжийг харж хяналтын 2 цэгийг сонгосон.
2 2-р цэг ЧД, 19-р хороо төслийн талбайн хашааны гадна тал	47°58'36.39"N 106°55'15.59"E	

7.2.3 Судалгааны арга, дээж авалт

Хөрсний дээжийг авахдаа MNS 3298:1990 “Байгаль хамгаалал, хөрсний шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлага стандартыг мөрдлөг болгон ажилласан. Хөрсний агрохими, хүнд металлын дээжийг “Инженер геодези” ХХК-ийн хөрсний итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэв.


Лабораторийн судалгааны арга зүй: Лабораторид дараах задлан шинжилгээг хийсэн байна. Үүнд:

1. Хөрсний механик бүрэлдэхүүн-Качинскийн арга, %;
2. Хөрсний урвалын орчин- Усан ханданд ионометрийн арга;
3. Хөрсний ялзмаг-Тюрингийн арга %;
4. Хөрсний давс-ионометрийн арга;
5. Хөрсний цахилгаан дамжуулах чанар-ионометрийн арга, ds/m;
6. Хөрсний карбонатын агууламж-кальциметрийн арга %;

7. Хөрсний солилцох сууриуд- (Ca, Mg) комплексметрийн арга, мг-экв/100 гр;
8. Хөрсний хөдөлгөөнт фосфор (P₂O₅)- 1% нүүрс хүчлийн аммоний уусмалд Мачигины арга, мг/100 гр хөрсөнд;
9. Хөрсний хөдөлгөөнт кали (K₂O)- 1% нүүрс хүчлийн аммоний уусмалд дөлийн фотометрийн арга, мг/100 гр хөрсөнд.

7.2.4 Хяналт-шинжилгээний үр дүн

Хүснэгт 8. Хөрсний морфологи шинж чанарын бичиглэл №1

Хөрсний морфологи бичиглэл		
Хөрсний зүсэлтийн дугаар	Зүсэлт №1	
Байршил	Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг	
Координат	47°58'39.922"N	
	106°55'11.982"E	
Огноо	2024.06.25	
Ургамлын бүрхэвч	Улалж-алаг өвст	
Хөрсний нэр	Уулын хар шороон хөрс	
Хөрсний фото	Гүн	Морфологи бичиглэл
	АВ. 0-20	Хар шороон өнгөтэй, бөөмөн үрлэн бүтэцтэй, делюв-пролювийн гарал үүсэлтэй жижиг үйрмэг чулуу 40-50 %, шавранцар, чийгтэй, нягт бага (1.3 гр/см ³), ургамлын үндэс их, давсны хүчилд бургихгүй, карбонатгүй, шилжилт өнгөөр жигд.

Хөрсний агрохимийн үндсэн үзүүлэлтүүд

Хүснэгт 9. Хөрсний агрохимийн шинж чанар

Дээжийн дугаар	Гүн, см	pH H ₂ O	ЦДЧ, dS/m	Давс	Ялзма Г, %	CO ₂ %	Солилцох суурь, мг-экв/100 гр			Шим тэжээлийн элементүүд мг/100 гр	
							Ca+Mg	Ca	Mg	P ₂ O ₅ , мг-экв	K ₂ O мг-экв
Зүсэлт-1	0-20	8.65	0.385	0.19	1.53	1.15	26.9	16.9	10.0	3.1	29.0
3-2 кемп	0-10	8.24	0.234	0.11	1.93	0.66	23.0	2.8	33.0	2.8	33.0

Шинжилгээний үр дүн: Химийн шинжилгээний үр дүнгээр хөрс нь шүлтлэг урвалын орчинтой, ялмагийн агууламж бага, карбонатлаг, шингээгдэх сууриудын нийлбэр хэмжээ дунд, цахилгаан дамжуулах чанар болон давсны агууламж бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор болон хөдөлгөөнт калийн хангамж их байна.

Хөрсний механик бүрэлдэхүүн

Хөрсний хатуу хэсгийг бүрдүүлж байгаа жижиг ширхгүүдийн хэмжээгээр нь ангилан тэдгээрийг хувиар илэрхийлснийг механик бүрэлдэхүүн гэнэ. Энгийн ширхгийн хэмжээгээр нь шороо ба чулуу гэсэн хоёр том бүлэгт хуваана. Хөрсний задлан шинжилгээнд бэлтгэхэд 1 мм-ийн шигшүүрээр шигших бөгөөд түүнээс том хэмжээтэйг чулуу, харин шигшигдэж орсон 1 мм-ээс бага ширхэгтэйг шороо гэнэ.

Хүснэгт 10. Хөрсний механик бүрэлдэхүүн

Дээжийн дугаар	Гүн, см	Механик бүрэлдэхүүн, % ширхгийн хэмжээ, мм						
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Зүсэлт-1	0-20	0.2	22.4	48.4	4.0	10.3	14.7	29.0
3-2 кемп	0-10	10.7	22.1	34.4	7.2	11.7	13.9	32.8

Хөрсний механик бүрэлдэхүүнийг тодорхойлох Н.А. Качинскийн ангиллын аргаар физик шаврын эзлэх хувиар тодорхойлоход шавранцар механик бүрэлдэхүүнтэй байна

Хөрсний бохирдол


Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламжийг тодорхойлох зорилгоор бид хүнд металлын холимог 2 дээж авч “Инженер геодези” ХХК-ийн хөрс судлалын итгэмжлэгдсэн лаборатори”-д Ni, Cd, Pb, Zn, Cr, Cu гэсэн 6 элементийг задлан шинжлүүлсэн. Шинжилгээний үр дүнг дэлгэрэнгүй байдлаар доорх хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 11. Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж

Зүсэлт	Дээж авсан гүн (см)	Хүнд металлын агууламж (мг/кг)					
		Хром (Cr)	Хар тугалга (Pb)	Кадмий (Cd)	Никель (Ni)	Цайр (Zn)	Зэс (Cu)
1	0-10	ND	14.14	ND	23.58	58.22	16.32
2 кемп	0-10	ND	14.12	ND	18.73	44.95	14.42
Хүлцэх агууламж /MNS 5850 : 2019/		150.0	100.0	3.0	150.0	300.0	100.0
Хортой агууламж /MNS 5850 : 2019/		400.0	500.0	10.0	1000.0	600.0	500.0
Аюултай агууламж /MNS 5850 : 2019/		1500.0	1200.0	20.0	1800.0	1000.0	1000.0

Хар хүрэн хөрсний 10 см-ийн авсан дээжид кадмий (Cd), хром (Cr) илрээгүй, хар тугалга (Pb) 14.12-14.14 мг/кг, цайр (Zn) 44.95-58.22 мг/кг, зэс (Cu) 14.42-16.32 мг/кг, никель (Ni) 18.73-23.58 мг/кг тус тус агуулагдаж байна. Эдгээр агууламж нь шавранцар механик бүрэлдэхүүнтэй хөрсний хувьд бүгд хүлцэх хэмжээнд байж, аюулгүй, “хэвийн” байна.

График 3. Төслийн талбайн 19-р хорооны нутгаас авсан хүнд металлын агууламж



7.2.5 Дүгнэлт, зөвлөмж

- Химийн шинжилгээний үр дүнгээр хөрс нь шүлтлэг урвалын орчинтой, ялзмагийн агууламж бага, карбонатлаг, шингээгдэх сууриудын нийлбэр хэмжээ дунд, цахилгаан дамжуулах чанар болон давсны агууламж бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор болон хөдөлгөөнт калийн хангамж их байна;
- Хөрсний дээжид хүнд металлын шинжилгээг атомын шингээлтийн спектрометрийн аргаар тодорхойлсон бөгөөд гарсан үр дүнг (MNS 5850: 2019) Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарттай харьцуулахад хүлцэх болон аюултай, хортой агууламжаас даваагүй байна;
- Хөрсний мониторингийн судалгааг жил бүр хийлгэхдээ нэг компаниар, хөрсний задлан шинжилгээ хийлгэсэн нэг лабораториор тус тус хийлгэж байх хэрэгтэй. Учир нь олон жилийн судалгааны тоон утга зөрөхгүй, үр дүнг тооцоход эргэлзээ үүсдэггүй сайн талтай.

7.3 Усны хяналт-шинжилгээ

7.3.1 Судалгааны зорилго

“Дамбадаржаа дулааны цахилгаан станц”-ын төслийн 2024 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн хөндлөнгийн мониторинг судалгаагаар унд, ахуйн усанд хяналт шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөхийг зорьсон.

7.3.2 Судалгааны арга зүй

Хээрийн судалгааны үер **холбогдох аргачлалын дагуу** Сэлбэ голын ус, унд-ахуйн зөөврийн ус болон хөрсний шавхан зайлуулж буй шүүрлийн уснаас тус бүр нэг нэг сорьц **авч** 2024 оны 06 сарын 25 болон 2024 оны 10 сарын 07-ны өдөр “Инженер геодези” ХХК-ийн хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн.

Хээрийн судалгаагаар дараах хэмжилт дээжлэлтийг хийсэн болно. Үүнд:

- Бичиглэл хийсэн он, сар өдөр;
- Хэмжилт, дээжлэлт хийсэн солбицол (WGS 1984 UTM Zone 48N);
- Гадаргын уснаас дээж авахдаа MNS ISO 5667-6:2001 “Гол горхины уснаас дээж авах заавар”-ын дагуу, худгаас дээж авахдаа MNS ISO 5667-11:2000 “Гүний уснаас дээж авах зөвлөмж” -ийн дагуу тус тус авсан. Үүнд:
 - Дээжлэлтийг хийхдээ эхлээд тусгай зориулалтын палиэтилен дээжийн саваа 3 удаа тухайн дээжлэлт хийх гэж байгаа усаар зайлна;
 - Үүний дараа дээжийн саваа дээжээр бүрэн дүүргэж дээр нь агаар байх зайгүйгээр таглана;
 - Ингэснээр тээвэрлэлтийн үед сэгсрэгдэх, хийнүүдийн хоорондох харилцан үйлчлэлийг хязгаарлана. Тээвэрлэлтийн үед дээжүүдийг харанхуй, сэрүүн хайрцагт хадгалсан;
- Унд, ахуйн ус болон хөрсний шавхан зайлуулж буй усны шинжилгээний үр дүнг MNS 0900:2018 (Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт) стандарттай харьцуулсан.
- Сэлбэ голын усыг MNS 4586:1998 (Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага) стандарттай харьцуулав.

7.3.3 Судалгаанд ашигласан багаж, тоног төхөөрөмж



Зураг 19. Ууссан хүчилтөрөгч хэмжигч /DO-метр АН.84183/



Зураг 20. TDS, EC, TDS- хэмжигч багаж



Зураг 21. Суурин pH метр

7.3.4 Зөөврийн усны хяналт-шинжилгээний үр дүн

Хүснэгт 12. Усны ерөнхий химийн шинжилгээ-Зөөврийн ус

№	Химийн шинжилгээний үзүүлэлтүүд	Зөөврийн ус, мг/л	MNS 0900: 2018, мг/л
1	Усан орчны (pH)	8.08	6.5-8.5
2	Cl ⁻	8.51	350.0
3	SO ₄ ⁻	4.59	500.0
4	NO ₃ ⁻	2.06	50.0
5	NO ₂ ⁻	0.03	1.0
6	CO ₃ ⁻	0.00	-

**2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН:
“ДАМБАДАРЖАА ДУЛААНЫ СТАНЦ БАРИХ” ТӨСӨЛ**

№	Химийн шинжилгээний үзүүлэлтүүд	Зөөврийн ус, мг/л	MNS 0900: 2018, мг/л
7	НСО ₃ ⁻	61.02	-
8	Na ⁺ +K ⁺	12.59	-
9	NH ₄ ⁺	0.10	1.5
10	Ca ²⁺	10.02	100.0
11	Mg ²⁺	3.65	30.0
12	Fe ²⁺	0.30	0.3
13	Fe ³⁺	0.00	-
